

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/212/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ТУУРГАТАН ТЕАТРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	16
4.3 Албан шаардлага.....	16
4.4 Зөвлөмж	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зууцмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/130
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН МОНГОЛ
ТУУРГАТАН ТЕАТРЫН ДАРГА
Д.НАМСРАЙНОРОВ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Монгол Туургатан театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Монгол Туургатан театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ
19020409

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	382,000,609.15	395,655,374.42
33	АВЛАГА	1,882,042.05	1,995,247.32
335	Бусад авлага	1,882,042.05	1,995,247.32
3351	Байгууллагаас авах авлага	1,252,042.05	1,365,247.32
3352	Хувь хүмүүсээс авах авлага	630,000.00	630,000.00
35410	Бичиг хэргийн материал	3,851,330.00	3,851,330.00
35420	Аж ахуйн материал	61,893,106.10	63,696,316.10
35430	Сэлбэг хэрэгсэл	1,635,000.00	1,635,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,114,284,725.65	9,871,863,177.77
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,114,284,725.65	9,871,863,177.77
392	Биет хөрөнгө	9,798,159,725.65	9,555,738,177.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,070,092,656.94	10,070,092,656.94
39202	Хуримтлагдсан элэгдэл	(404,046,738.41)	(601,638,509.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,920,000.00	84,920,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(84,920,000.00)	(84,920,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	156,695,333.70	156,695,333.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(113,732,849.90)	(128,709,826.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	202,552,105.64	202,552,105.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(113,400,782.32)	(143,253,582.28)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,884,285.70	15,884,285.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,884,285.70)	(15,884,285.70)
393	Биет бус хөрөнгө	316,125,000.00	316,125,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	316,125,000.00	316,125,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,496,285,334.80	10,267,518,552.19
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,496,285,334.80	10,267,518,552.19
51	Засгийн газрын хувь оролцоо	10,496,285,334.80	10,267,518,552.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	816,099,394.39	816,099,394.39
51101	Өмч: - төрийн	499,974,394.39	499,974,394.39
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	316,125,000.00	316,125,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	9,502,184,832.04	9,273,418,049.43
51210	Өмнөх үеийн үр дүн	9,502,184,832.04	9,502,184,832.04
51220	Тайлант үеийн үр дүн	-	(228,766,782.61)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,001,108.37	178,001,108.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	10,496,285,334.80	10,267,518,552.19

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	8,174,646.00	6,541,900.00
210401	Бичиг хэрэг	3,628,250.00	4,027,600.00
210402	Тээвэр, шатахуун	2,600,200.00	1,006,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,946,196.00	1,508,040.00
2107	Томилолт, зочны зардал	2,496,000.00	72,000.00
210702	Дотоод албан томилолт	2,496,000.00	72,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	172,640,399.05	34,987,994.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	170,673,899.05	33,402,234.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,140,000.00	1,140,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,500.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	550,000.00	191,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	233,974,119.44	242,421,547.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	233,974,119.44	242,421,547.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,353,675.50	78,516,108.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,401,400.00	43,607,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,903,900.00	43,309,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	497,500.00	298,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	27,952,275.50	34,908,808.59
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(61,476,191.49)	(228,766,782.61)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(61,476,191.49)	(228,766,782.61)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,563,661,023.53	10,557,761,526.29
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,563,661,023.53	10,557,761,526.29
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-61,476,191.49	-61,476,191.49
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,502,184,832.04	10,496,285,334.80
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,502,184,832.04	10,496,285,334.80
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,502,184,832.04	10,496,285,334.80
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-228,766,782.61	-228,766,782.61
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	816,099,394.39	178,001,108.37	9,273,418,049.43	10,267,518,552.19

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,448,631,700.00</u>	<u>1,426,674,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,638,900.00	
120	Нийтлэг татварын бус орлого	1,638,900.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,638,900.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,638,900.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,446,992,800.00	1,424,849,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	8,925,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	7,100,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,825,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,443,992,800.00	1,417,749,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,443,992,800.00	1,417,749,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,448,631,700.00</u>	<u>1,426,674,000.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,448,631,700.00	1,426,674,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,362,278,024.50	1,348,157,891.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,546,607.19	700,684,582.91
210101	Үндсэн цалин	564,459,362.16	473,509,734.74
210102	Нэмэгдэл	111,678,115.63	179,180,664.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,409,129.40	47,994,183.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,114,070.31	92,225,766.50
210201	Тэтгэврийн даатгал	80,271,736.19	64,350,140.18
210202	Тэтгэмжийн даатгал	9,686,031.91	7,158,789.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,403,385.37	5,659,830.84
210204	Ажилгүйдлийн даатгал	334,966.35	1,343,959.83
210205	Эрүүл мэндийн даатгал	3,417,950.49	13,713,046.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	505,078,727.00	499,990,882.00
210301	Гэрэл, цахилгаан	10,410,487.00	5,869,562.00
210302	Түлш, халаалт	489,060,000.00	489,060,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,608,240.00	5,061,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,413,050.00	11,130,000.00
210401	Бичиг хэрэг	2,926,050.00	4,475,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,298,000.00	1,006,260.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,988,000.00	1,508,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,201,000.00	2,700,600.00

2105	Нормативт зардал	3,634,000.00	1,134,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,634,000.00	1,134,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	250,000.00
210604	Урсгал засвар	-	250,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,496,000.00	72,000.00
210702	Дотоод албан томилолт	2,496,000.00	72,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,995,570.00	42,670,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,029,070.00	41,084,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,140,000.00	1,140,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,500.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	550,000.00	191,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,353,675.50	78,516,108.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,401,400.00	43,607,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,903,900.00	43,309,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	497,500.00	298,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,952,275.50	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,952,275.50	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	34,908,808.59
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	34,908,808.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,417,749,000.00	1,382,843,221.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,417,749,000.00	1,382,843,221.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,374,023,300.00	1,339,235,921.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	704,588,600.00	700,684,582.91
210101	Үндсэн цалин	562,420,300.00	473,509,734.74
210102	Нэмэгдэл	120,691,700.00	179,180,664.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,476,600.00	47,994,183.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,119,500.00	92,225,766.50
210201	Тэтгэврийн даатгал	66,935,900.00	64,350,140.18
210202	Тэтгэмжийн даатгал	7,045,900.00	7,158,789.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,636,700.00	5,659,830.84
210204	Ажилгүйдлийн даатгал	1,409,200.00	1,343,959.83
210205	Эрүүл мэндийн даатгал	14,091,800.00	13,713,046.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	527,288,300.00	499,990,882.00
210301	Гэрэл, цахилгаан	24,511,500.00	5,869,562.00
210302	Түлш, халаалт	489,060,000.00	489,060,000.00
210303	Цэвэр, бохир ус	13,716,800.00	5,061,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,295,300.00	10,292,960.00
210401	Бичиг хэрэг	3,826,100.00	3,826,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,008,100.00	1,006,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,000.00	1,320,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,440,000.00	1,440,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,701,100.00	2,700,600.00
2105	Нормативт зардал	1,134,000.00	1,134,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,134,000.00	1,134,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	250,000.00	250,000.00
210604	Урсгал засвар	250,000.00	250,000.00
2107	Томилолт, зочны зардал	324,600.00	72,000.00
210702	Дотоод албан томилолт	324,600.00	72,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,023,000.00	34,585,730.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,000,000.00	32,999,970.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,140,000.00	1,140,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	150,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	71,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	550,000.00	191,260.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,725,700.00	43,607,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,725,700.00	43,607,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,309,000.00	43,309,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	416,700.00	298,300.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,417,749,000.00	1,382,840,191.41
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	884,852,000.00	1,382,840,191.41
320001	Орон нутгийн төсвөөс	884,852,000.00	1,382,840,191.41
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	532,897,000.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	532,897,000.00	0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	131	131
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33
620003	Үйлчлэх ажилтан	31	31
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65	65
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1	1
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	33	33
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	31	31

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,925,000.00	8,925,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,925,000.00	8,925,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,921,970.00	8,921,970.00
2104	Хангамж, бараа материалын зардал	837,040.00	837,040.00
210401	Бичиг хэрэг	649,000.00	649,000.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	188,040.00	188,040.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,084,930.00	8,084,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,084,930.00	8,084,930.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,030.00	3,030.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,030.00	3,030.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3,030.00	3,030.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,925,000.00	8,925,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,925,000.00	8,925,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,100,000.00	7,100,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,825,000.00	1,825,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Монгол Туургатан театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Монгол Туургатан театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Монгол Туургатан театр нь Үндэсний соёл, урлагаа уламжлал шинэчлэлээр баяжуулан хөгжүүлж, хүн амд хүргэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, бүх талын тааламжтай орчин нөхцлийг бүрдүүлсэн, орон нутгийн хэмжээнд бүх чиглэлийн тэргүүлэх үйл ажиллагаа явуулдаг театр болох зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Монгол Туургатан театрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Монгол Туургатан театрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Монгол Туургатан театрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Монгол Туургатан театрын даргын 2020 оны А/02 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг байгуулж үйл

ажиллагааны төлөвлөгөө, шалгалт явуулах хуваарийг баталсан байна. 2021 онд төлөвлөсөн ажлуудаас цар тахалаас шалтгаалан зарим ажлууд хийгдээгүй байна.

Төв аймгийн Монгол Туургатан театрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Монгол Туургатан театрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр он санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 725,431.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,881.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,705.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Монгол Туургатан театрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд дахин шинэчлэн тооцох шаардлагагүй гэж үзэж 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 725,431.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,881.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8,705.1 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Монгол Туургатан театрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 1,417,749.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,825.0 мянган төгрөг, аймгийн төсвөөс 7,100.0 мянган төгрөг нийт 1,426,674.0 мянган төгрөг, өмнөх оноос 316,388.1 мянган төгрөгөөр буюу 18 хувиар буурсан байна. Энэ нь санхүүжилт буурсантай холбоотой байна.

Зардал:

Төв аймгийн Монгол Туургатан театр нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 1,655,440.7 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,426,674.0 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,382,843.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140035012 тоот дансанд 2021 онд 1,417,749.0 мянган төгрөгийн орлого, 1,417,749.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140035404 тоот дансанд 8,925.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 8,925.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,882.0	2,008.7	126.7
Урьдчилгаа			
Бараа материал	380,118.5	393,646.6	13,528.0
Үндсэн хөрөнгө	10,114,284.7	9,871,863.1	-242,421.5
Нийт хөрөнгө	10,496,285.3	10,267,518.5	-228,766.7
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	10,496,285.3	10,267,518.5	-228,766.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,496,285.3	10,267,518.5	-228,766.7

Авлага дансны үлдэгдэл 2,008.7 мянган төгрөг болж өссөн нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 393,646.6 мянган төгрөг болж 13,528.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материалын худалдан авалтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 9,871,863.1 мянган төгрөг болж 242,421.5 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдэлтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн дансанд нэмэгдсэн, хасагдсан өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,267,518.5 мянган төгрөг болж 228,766.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,568,793.7 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,516,674.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 151.1 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 1,447,749.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь байр ашиглахтай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,417,749,0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,417,749,0 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,417,749,0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,382,843.2 мянган төгрөгийг зарцуулж, 34,905.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,382,843.2 мянган төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь ковид цар тахалтай холбоотой урлаг соёлын үйл ажиллагаа явагдаагүй тул цахилгаан, цэвэр бохир ус хэмнэсэн үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Монгол Туургатан театр тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,825.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын захирамжаар 7,100.0 мянган төгрөг нийт 8,925.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардал бичиг хэргийн зардалд 649.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 188.0 мянган төгрөг, уран бүтээлийн зардалд 8,084.9 мянган төгрөг, нийт 8,922.0 мянган төгрөгийг зарцуулжээ. Орон нутгийн төсөвт 3.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Монгол Туургатан театрт онцолсон асуудал байхгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Монгол Туургатан театр нь нийгмийн даатгалын шимтгэл 1,365.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 145 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 28 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орлогын бүртгэлийн талаар дараагийн аудитаар анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,048.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 1,365.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 19,683.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичив.

4.2 Төлбөрийн акт

Нийгмийн даатгалын шимтгэлийн 1,365.2 мянган төгрөгийн авлага үүсгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.4-д “төсвийн байгууллага нь батлагдсан тооноос дутуу орон тоогоор ажилласнаас бий болсон төсвийн үлдэгдэл” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэсэн заалтын дагуу төлбөрийн акт тогтоов.

Он дамжсан цалингийн урьдчилгааны авлага 630.0 мянган төгрөгийг төлүүлж барагдуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.4-д “төсвийн байгууллага нь батлагдсан тооноос дутуу орон тоогоор ажилласнаас бий болсон төсвийн үлдэгдэл” гэсэн заалтууд болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэсэн заалтын дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 17,184.6 мянган төгрөгөөр дутуу, 2,498.8 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг

цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Монгол Туургатан театр	3	21,678.7			2	1,995.2	1	19,683.5		